

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 дугаар сарын 17-ны өдөр

№ 26/36

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20, 9.6.23 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн АХ-26/12 тоот дүгнэлт болон 2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь бизнесийн зээлийн багцын өсөлтийг тогтвортой, эрсдэл багатай хангах зорилгоор кредит скорингийн моделиудын сайжруулалтуудыг тогтмол хийж, харилцагчийн хэрэгцээнд тохирсон зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох, зээлийн чанарыг дээшлүүлэхээр ажиллаж байгаа болохыг дурдсугай.
2. Компанийн зүгээс (i) зээлийн бодлогын тогтолцоог үнэлж, боловсронгуй болгох, (ii) харилцагчийн сегментчлэлийн тогтолцоо боловсруулах, (iii) зээл судлан шийдвэрлэх үйл явцыг шинэчлэх, (iv) кредит скорингийн загварын стратегийг шинэчлэх, хөгжүүлэх ажлын хүрээнд Кацухико Мадонотай “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-г байгуулахыг зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2 дахь хэсэгт заасан зөвлөх үйлчилгээний цар хүрээг нарийвчлан тогтоож, Кацухико Мадонотай “Зөвлөх үйлчилгээний гэрээ”-г байгуулах, түүнд гарын үсэг зурж, баталгаажуулах, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, түүний үр дүн болон энэхүү тогтоолын дагуу байгуулагдсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ талаар тухай бүр Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 дугаар сарын 17-ны өдөр

№ 26/37

Улаанбаатар хот

**Дотоод аудитын дүрэм
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн АХ-26/13 тоот дүгнэлт болон 2026 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Дотоод аудитын дүрэм”-ийг Дотоод Аудитын Олон Улсын Стандартын шинэчилсэн шаардлагад нийцүүлэх, дотоод аудитын үйл ажиллагааны бие даасан, хараат бус, үр нөлөөтэй байдлыг улам нэмэгдүүлэх зорилгоор энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, мөрдөж ажиллахыг Компанийн Дотоод аудитор (Б.Алтантуяа), Мэдээллийн технологийн аудитор (М.Ариунболд) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Компанийн Дотоод аудитын дүрэм шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 21/01 тоот тогтоол, Гүйцэтгэх захирлын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 2022/129 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Компанийн Дотоод аудитын дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга (С.Нэргүй)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

